



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 115

Улаанбаатар хот

Барилга байгууламж акталж, нийслэлийн  
өмчийн бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн Чингэлтэй дүүрэг дэх 108 дугаар цэцэрлэгийн хуучин барилгыг буулгаж, шинээр цэцэрлэг барих болсонтой холбогдуулан тус цэцэрлэгийн баланст бүртгэлтэй нийт 637,727,135.00 (зургаан зуун гучин долоон сая долоон зуун хорин долоон мянга нэг зуун гучин таван) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 136,252,475.92 (нэг зуун гучин зургаан сая хоёр зуун тавин хоёр мянга дөрвөн зуун далан таван төгрөг ерэн хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад дурдсан барилга байгууламж болон нийтийн эзэмшлийн хөрөнгийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110101118

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн  
115 дугаар тогтоолын хавералт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон он	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2024.06.30/	Үлдэгдэл өртөг
1	Цэцэрлэгийн барилга /хоёр давхар/	м2	1063.2	1986	606,105,205.00	118,347,104.88	487,758,100.12
2	Бохирын шугам	м	85	1986	6,243,250.00	5,722,979.46	520,270.54
3	Цахилгааны шугам	м	32	1986	328,000.00	328,000.00	0.00
4	Тоглоомын талбай	м2	227	1986	4,920,225.00	4,920,225.00	0.00
5	Бетон хучилттай явган зам, талбай	м2	582	1986	4,794,225.00	4,394,706.36	399,518.64
6	Шигтгэмэл хавтан хучилттай явган зам, талбай	м2	240	2011	8,310,960.00	2,539,460.22	5,771,499.78
7	Бут , сөөг	ш	905	2018	4,615,500.00	-	4,615,500.00
8	Шилмүүст мод	ш	51	2018	1,992,570.00	-	1,992,570.00
9	Навчит мод	ш	56	2018	417,200.00	-	417,200.00
	<b>Нийт дүн</b>				<b>637,727,135.00</b>	136,252,475.92	501,474,659.08